

“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ийн 2015 оны жилийн

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:

Хаяг: Дархан Уул аймаг, Дархан сум 11-р баг компанийн өөрийн байр утас: 70377160

Электрон хаяг: servise@darhan hotel.mn

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

Компанийн нэр: “Дархан зочид буудал” ХК

Улсын бүртгэлийн дугаар: 2003006754

Регистрийн дугаар: 0004757

Үйл ажиллагааны чиглэл: Зочид буудал, ресторан

Нийт гаргасан хувьцаа: 89453 ширхэг энгийн хувьцаа

3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:

2015 онд ашиг орлогоо нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчийн тав тухыг хангасан орчин бүрдүүлэх, хоолны нэр төрлөө өөрчлөх амт чанарыг сайжруулах зорилт тавин ажиллав.

1. Үндсэн үйл ажиллагаа

Дархан зочид буудал ХК нь 2015 онд зочид буудал, зоогийн газар, фитнес, караоке, саун, баарны үйлчилгээ

Хөдөлмөрийн сахилга бат, бүтэц зохион байгуулалтын чиглэлээр:

Бүх ажилчдад үйлчилгээний соёл, зочид буудлын стандартаар 6 цагийн хичээл, зоогийн газрын ажилтнуудад зоогийн газарт мөрдөгдөх дүрэм журам, хоолны газрын үйлчилгээ, зохион байгуулалт, технологийн талаар онол дадлагын 25 цагийн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн чиглэлээр 2 цаг, газтай харьцах аюулгүй ажиллагааны чиглэлээр 2 цаг, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, тамхины хяналтын тухай хуулийн талаарх сургалтуудыг ажлын байран дээр зохион байгуулж мэдлэгийг дээшлүүлсэн.

Байгууллагад шинээр гарсан мөрдөгдвөл зохих дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаагаа нийцүүлэн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, зочид буудлын дүрэм, угтагч нарын мөрдөж ажиллах журам, хүнсний аюулгүй байдалд мөрдөх шалгуур үзүүлэлт зэргийг мөрдүүлж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг хариуцсан ажилтанг томилж, ажилтнуудыг ажилдаа орох бүрт нь аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байна.

Ажиллагсдыг өдөр тутам хийсэн ажлыг нь үнэлж, ажлыг дүгнэдэг болгосон

Дотоод хяналтын чиглэлээр батлагдсан төлөвлөгөөний дагуу 27 удаа хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг бүрэн засуулж, дотоод хяналт, шалгалтын тайланг аймгийн МХГ-т хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Цалинг тодорхой хэмжээнд 1 удаа нэмэгдүүлсэн ба цалингын доод түвшин 350.000 төгрөг, дундаж цалин 500.000 төгрөг байна.

Дархан-Уул аймгийн 2015 оны “Худалдаа үйлчилгээний салбарын хөдөлмөрийн аварга”-аар манай компанийн тогооч шалгарлаа.

3.Үйлчилгээний соёл, стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр:

“Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл үндсэн шаардлага MNS 4588:2004“ стандартын хэрэгжилт 75%, “Хоолны газрын ангилал зэрэглэл үндсэн шаардлага MNS 4557:2005 стандартын хэрэгжилт 75% тай байна.

Рестораны менюг шинэчлэн стандартад нийцүүлэн англи, монгол хэл дээр хийлгэж, “Хаадын зоог” нэрийн багц хоолнуудыг шинээр гарган үйлчилж байна.

Зах зээлийн хямрал, рестораны өдөр тутмын орлого муудсантай холбогдуулан өдрийн хоолны багц, хямд үнэтэй хоолнуудыг тусгайлан гаргаж нийтэд сурталчилгаа хийн түүгээр үйлчилж байна.

Үйлчилгээний соёлыг сайжруулах зорилгоор Рестораны болон зочид буудлын ресепшин хаалгач нарт ажлын цамц , тогооч нарт хормогч, малгай, үйлчлэгч нарыг ажлын хувцсаар хангасан

Рестораны халуун цехэд засварын ажил хийж, хуучин агааржуулалтын системийг ажилладаг болгосон.

Ресторанд гэрэлтүүлэг нэмж, хөгжим дуу гаралт, дефузерүүдийг сонсголын түвшинд байрлуулснаар дуу гаралт сайжирсан, тайзны эмх цэгцийг сайжруулж хөгжмийг тусгай хаалтанд байрлуулсан.

Ресторанд 3 өнгийн ширээний бүтээлэг /молот/ , зөөгч нарт гарын даавуун салфетка, лааны суурь, ажлын цагаан цамц авч өгч, Рестораны 00-н өрөөнд хогийн савыг шинэчлэн сольсон.

Үйлчилгээний орчныг сайжруулах зорилгоор А корпусын 2, 3 давхрын цонх, Б корпусын 2 давхрын 7 өрөөний хуучирч өгөршин, зай завсартай болсон цонх, палконыг вакум болгож чулуун тавцантай болгосон.

Буудлын 1,2,3,4 давхрын халуун болон хүйтэн усны хэвтээ босоо шугамуудад гарсан гэмтлүүдийг засварлаж, шинэчилсэн.

2015 онд 10,383,600.00 төгрөгний эд хогшил худалдан авч, зочид буудлын болон рестораны эвдэрсэн болон элэгдэж ашиглах боломжгүй болсон 31,389,046,60 төгрөгийн эд хогшлыг актлав.

Зочид буудлын 4 давхрын 3 өрөөнд 00-н өрөөнөөс бусад хэсэгт урсгал засвар хийсэн.

Б корпусын 3 өрөөнд телевизор авч, хуучин телевизоруудыг А корпус т шилжүүлсэн.

Зочид буудлын өрөөнүүдэд дутуу байсан дотуур холбооны утаснуудыг гүйцээж хийлгэн, мөн ажиллагаагүй болсон байсан 5 камеруудыг засварлуулав.

Зочид буудлын өрөөнүүдийн ванны болон гарын алчуурыг шинэчлэн логотой болгон, мөн өөрийн логотой нэг удаагийн хэрэгслийг нийлүүлсэн, буудлын өрөөнүүдийн актлагдсан орны бүтээлгийг шинэчлэн солив.

Онцгой байдлын газрын шаардлагын дагуу галын даралтат усны хоолойнуудыг ажиллагаанд оруулж бэлэн байдлыг хангуулсан.

Сауныг ашиглалтад оруулж доторхи тохижилт, цахилгаан болон сантехникийн бүхий л асуудлыг шийдвэрлэсэн. Мини бассейн тэй болгосон.

Угаалгын газарт хатаагч төхөөрөмж нэмж авч өгч хүчин чадлыг сайжруулсан.

Зочид буудлын гадна талын дээд болон өмнөд хэсэгт туузан гэрлэн чимэглэл, бүх моднууддаа гэрлэн чимэглэл хийж орчноо тохижуулав.

Хогийн цэгийн савыг шинээр хийлгэж цоожтой болгон талбайг цементлүүлсэн, гадна талд байрлаж байгаа бохирын худгуудыг гэрээгээр цэвэрлүүлж бохир халихаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан.

Зочид буудлын 3, 4 давхрын цахилгаан их хэрэглэдэг улайсах лампуудыг сольж цагаан гэрэлтэй болгосон.

Зочид буудлын ресепшин, хаалгач, үйлчлэгч нарын ажлын уялдаа холбоог сайжруулахаар ажил хүлээлцдэг бүртгэлтэй болгон өрөө бүрийг нэг бүрчлэн шалгаж хүлээн авдаг болгов.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд дулааны төв хаалтыг солиулан, тоолуураа баталгаажуулсан, зочид буудлын өрөөнд цоорч зэвэрсэн 8 радиаторыг шинэчилэн солив.

Буудлын 1 давхрын коридорын хана хөгцөрч мөөгөнцөртсөн байсан тул засвар хийсэн.

Рестораны хувцасны өлгүүрийн дотор заслын ажлыг хийж, хувцас авах цонх гаргуулан, өлгүүрийг шинэчлэн, бүх дугааруудыг хуучин цоожны төмөр ашиглан шинээр хийв.

Баарны түрээсийг болиулж өөрсдөө орон тооны ажилтантай болгон ажиллуулж байна. Доод зоорийн давхрыг нэг бүрчлэн цэвэрлэж хогийг ялган хаяж хулганы хор тавиулав.

3.Ашиг орлогоо нэмэгдүүлэх менежментийн чиглэлээр:

1. Хоолны меню, бүтцийг өөрчилсөн

2.Зоогийн газрын материаллаг баазыг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг хөрөнгө авсан, ажлын байрны зохион байгуулалтыг өөрчилж, зоогийн газрын менежертэй болсон, ур чадвар өндөртэй тогооч нарыг авч ажиллуулан, 6 төрлийн сеть хоолны меню шинээр нэмж гарган 10 төрлийн соусыг шинээр хийж эхэлсэн.Зах зээлийн болон өрсөлдөгч байгууллагуудын үнийн судалгааг тогтмол хийж үнийн өөрчлөлтийг тухай бүр хийж ажиллав.

Хамтран ажиладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын удирдлагуудад танилцуулах хоолны өдөрлөг зохион байгуулсан нь үр дүнгээ өгч захиалгаар үйлчилгээ үзүүлэх боломж бүрдсэн.

3. Зочид буудлын өрөөний үйлчилгээ, ажлын хариуцлагыг сайжруулах, зорилгоор өрөө бүрийг өдөр тутам хүлээлцэж журнал хөтлөх, гарсан гэмтэл засварыг цаг алдалгүй хийх зэрэг

4. Харилцагч байгууллагуудад хамтран ажиллах санал, үйчилгээний талаарх мэдээллийг хүргүүлж ажиллав.

5. Өрөөнүүдийн үйлчилгээг сайжруулах зорилгоор LED телевизор, дотуур утас тавьсан, цагаан хэрэглэл 1 ээлжийг бүрэн шинэчилсэн

6. Зоогийн газар, зочид буудлуудыг сүлжээгээр холбосон санхүүгийн программтай болгов.

7. Томоохон хүлээн авалтуудын зориулалтанд тохируулж тухайлбал хурим, шинэ жилийн арга хэмжээ, одонгын найр зэрэг чиглэлүүдээр заалны засалт хийж үнэлгээндээ оруулдаг, хөтлөгч, дуучидын захиалгыг авч хамтарч ажиллан тодорхой орлогыг тохирч авдаг болгов.

4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

Дархан зочид буудал нь Дархан хотод 1982 онд үйл ажиллагаагаа төрийн мэдэлд явуулж эхэлсэн 1997 онд хувьчлагдсан Дархан хотын анхны зориулалтын барилга байгууламжтай зочид буудал зоогийн газрын иж бүрэн цогцолбор юм.

Хотын төвийн А бүсэд байрлалтай 17000 метр кв талбай бүхий эдэлбэр газартай гадна орчны 80 хувь нь ногоон байгууламжтай, гэрэлтүүлэгтэй камертай, авто машины үнэгүй зогсоолтой, цэвэр бохир усны төвлөрсөн систем, дулаанд холбогдсон.

Дархан зочид буудал нь 3 одтой зочид буудлын зэрэглэл хангахуйц тохилог, зочид хүлээж авах А, Б корпустай, нэг ээлжиндээ 110 зочин хүлээн авах хүчин чадалтай, 56 өрөөтэй, өрөөнүүд нь стандарт, /хагас люкс, люкс/ гэсэн зэрэглэлтэй бүх өрөөнүүдэд мини бар, дотуур холбоотой, утасгүй интернэттэй, кабелийн суваг бүхий LCD телевизортой, зочид буудалд буусан зочдоо өглөөний цайгаар үнэгүй үйлчилдэг зочдод зориулсан 24 цагийн өрөөний үйлчилгээ, караоке, үдшийн цэнгээний газар, саун, фитнес клуб, хувцас угаах, хурлын заал зэргээр үйлчлэх бүрэн боломжтойн дээр камержсан зочдын машиныг байрлуулах гражтай.

Дархан ресторан нь нэг ээлжиндээ 150-200 зочин хүлээн авах хүчин чадалтай хоолны 3 танхимтай европ, монгол, хятад гэсэн орнуудын олон төрлийн захиалгат хоолоор үйлчилдэг.

Санхүүгийн талаар:

Тус компанийн 2015 оны борлуулалтын орлогыг 12 сараар нь харьцуулан харуулбал:


мянган төгрөгөөр

Д/д	Сарууд	Зочид буудлын орлого	Зоогийн газрын орлого	Бусад орлого
1	1-р сар	3731.8	14421.4	327.3
2	2-р сар	2290.9	14551.9	272.7
3	3-р сар	3613.4	17687.3	366.4
4	4-р сар	5980.0	12177.4	687.3
5	5-р сар	13425.7	11280.7	390.9
6	6-р сар	8367.5	17050.9	445.4
7	7-р сар	9020.7	12249.7	279.1
8	8-р сар	10099.1	16742.6	272.7
9	9-р сар	2871.8	39222.9	272.7
10	10-р сар	5055.4	33226.7	272.7
11	11-р сар	4600.9	16892.6	272.7
12	12-р сар	3040.4	37701.6	1636.4
Нийт дүн		72097.6	243205.9	5496.3

Хүснэгтээс харахад нийт орлогын 75,82 хувийг зоогийн газрын орлого, 22,47 хувийг зочид буудлын орлого үлдсэн 1,71 хувийг бусад орлого буюу заалны түрээсийн орлого эзэлж байна.

Үүнийг графикаар харуулбал:

2015 оны орлогын тайлангийн үзүүлэлтүүдийг өмнөх онтой харьцуулан харуулбал:



сая төгрөгөөр

№	Үзүүлэлтүүд	2014 он	2015 он	Зөрүү	өсөлт бууралт
1	Борлуулалтын орлого	396,0	320,8	-75,2	18,9% буурсан
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	355,0	315,1	-39,9	11,2% буурсан
3	Нийт ашиг	41,0	5,7	-35,3	86,1% буурсан
4	Хүүний орлого	0,07		-0,07	100 % буурсан
5	Ерөнхий ба удирдлагын зардал	42,7	39,3	-3,4	7,9% буурсан
6	Бусад зардал	0,6		-0,6	100% буурсан
7	Ашиг алдагдал	(2,2)	(42,2)	40,0	


5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт:

2014 он болон 2015 оны орлогын тайлангийн үзүүлэлтүүдийн харьцуулалтаас харахад эдийн засгийн хямралтай нөхцөл байдал болон өрсөлдөгч аж ахуйн нэгж байгууллагууд олноор гарч ирсэнтэй холбоотойгоор үзүүлэлтүүд бүгд буурсан үзүүлэлттэй байна.

Ерөнхий ба удирдлагын зардалын хэмжээ огцом өсөлт бууралтгүй харин бусад зардлын хэмжээг 100% хүртэл бууруулж чадсан.

2014 он болон 2015 оны борлуулалтын орлогын хэмжээг графикаар харуулбал:

мянган төгрөгөөр



Компанийн 2014 болон 2015 оны хөрөнгө эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

сая төгрөгөөр

Хөрөнгө өр төлбөрийн үзүүлэлтүүд	2014 он	2015 он	Өсөлт бууралт
Эргэлтийн хөрөнгө	125,4	154,2	22,9%
Эргэлтийн бус хөрөнгө	1037,5	1009,1	2.7% бууралт
Нийт хөрөнгийн дүн	1162,9	1163,3	0.03%
Богино хугацаат өр төлбөр	368,9	374,6	1.5%
Урт хугацаат өр төлбөр	0	0	
Эзэмшигчдийн өмчийн дүн	794,0	755,9	4.8% бууралт
Өр төлбөр эзэмшигчийн өмчийн дүн	1162,9	1163,3	0,03%

6. Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл:

Намсрай овогтой Мөнхдаш / ТУЗ-ийн дарга/ -79.48 хувь

7. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтаны танилцуулга:

Овог нэрс	Албан тушаал
Н.Мөнхдаш	ТУЗ-ийн дарга

Л.Ариунзаяа	Гүйцэтгэх захирал
П.Алимаа	ТУЗийн гишүүн
Б.Мягмардаш	ТУЗийн гишүүн
П.Эрдэнэ бат	ТУЗ ийн гишүүн
Н.Пүрэвдаш	ТУЗ ийн гишүүн
Л.Ариунтуяа	ТУЗ ийн хараат бус гишүүн
О.Хүрэлчулуун	ТУЗ ийн хараат бус гишүүн
Д. Дархан баяр	ТУЗ-ийн гишүүн
С. Дагиймаа	ТУЗийн нарийн бичиг

8. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчийн мэдээлэл:

Н.Мөнхдаш “Бурхан халдун групп”ХХК -ийн ерөнхий захирал 79.48 хувь

9. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

Санхүүгийн тайлангаа холбогдох хуулийн дагуу улирлын тайлан,хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажсан жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.3, Аудитын тухай хуулийн 10.2.1 д заасаны дагуу Татварын хэлтэс, МХБ, СЗХ зэрэг байгууллагуудад хүргүүлдэг.

2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан:

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дархан Зочид Буудал ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

2015 оны 12 сарын 31 өдөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2014 оны 12-р сарын 31	2015 оны 12-р сарын 31-ний шинэчилсэн үлдэгдэл ¹
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	21.962.032,10	416.300,43
1.1.2	Дансны авлага		1.598.850,00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1.258.474,68	
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	102.096.704,03	152.193.487,47
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	125.317.210,81	154.208.637,90
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1.030.311.130,75	1.002.670.625,68
1.2.2	Биет бус хөрөнгө	7.171.153,84	6.471.153,84
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1.037.482.284,59	1.009.141.779,52
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1.162.799.495,40	1.163.350.417,42
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	354.480.294,75	374.598.403,35
2.1.1.2	Цалингийн өглөг	2.784.907,00	3.530.359,00
2.1.1.3	Татварын өр	4.549.750,66	18.464.382,00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	1.431.939,06	9.381.978,00
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	1.442.473,00	1.442.473,00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	364.689.364,47	407.417.595,35

¹2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн тус үлдэгдэлд 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө мэдүүлэх, бүртгүүлэх, тайлагнах үүргээ биелүүлээгүйн улмаас холбогдох албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа нэмж тайлагнана. Ингэхдээ 2015 оны 1-р улиралд тайлагнасан дүнг оруулахгүй ба зөвхөн тус улиралд нуун дарагдуулсан хөрөнгө, орлого, үйл ажиллагааг 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэлд нэмж оруулна.

CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН(үргэлжлэл)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2014 оны 12-р сарын 31	2015 оны 12-р сарын 31-ний шинэчилсэн үлдэгдэл ²
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	364.689.364,47	407.417.595,35
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн		
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат	8.945.300,00	8.945.300,00
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	353.195.120,07	353.195.120,07
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	571.515.879,38	571.515.879,38
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(135.546.168,52)	(177.723.477,38)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	798.110.130,93	755.932.822,07
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1.162.799.495,40	1.163.350.417,42

Захирал  (.....)

Ерөнхий нягтлан бодогч  (.....)



"DALAYAN AUDIT" CO.,LTD
CERTIFIED ACCOUNTING AUDITING
& APPRAISAL

²2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн тус үлдэгдэлд 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө мэдүүлэх, бүртгүүлэх, тайлагнах үүргээ биелүүлээгүйн улмаас холбогдох албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа нэмж тайлагнана. Ингэхдээ 2015 оны 1-р улиралд тайлагнасан дүнг оруулахгүй ба зөвхөн тус улиралд нуун дарагдуулсан хөрөнгө, орлого, үйл ажиллагааг 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэлд нэмж оруулна.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дархан Зочид Буудал ХК

2015 оны 12 сарын 31 өдөр

(Аж
/төгрөгөөр/

ахуйн

нэгжийн

нэр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2014 оны 12-р сарын 31	2015 оны 12-р сарын 31-ний шинэчилсэн дүн ⁵
1	Үндсэн үйлжиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	440,403,943.00	351,280,960.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	436,963,521.00	351,280,960.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	С, санхүүжилтийн орлого		
	Д мөнгөн орлого	3,440,422.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	401,747,202.48	363,819,091.67
	Ажиллагчдад төлсөн	93,629,921.02	122,811,823.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	26,021,741.51	23,576,590.00
	Хараа материал худалданавахад төлсөн	147,297,471.18	112,338,806.00
	Ашиглалтын зардалд төлсөн	48,525,758.00	51,918,402.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	37,961,071.50	18,378,092.00
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	48,311,239.27	34,795,378.67
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	38,656,740.52	(12,538,131.67)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(44,013,570.45)	(9,007,600.00)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(44,013,570.45)	(9,007,600.00)
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(44,013,570.45)	(9,007,600.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(5,356,829.93)	(21,545,731.67)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,318,862.03	21,962,032.10
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,962,032.10	416,300.43

⁵2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн тус дүнд 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө мэдүүлэх, бүртгүүлэх, тайлагнах үүрэгээ биелүүлээгүйн улмаас холбогдох албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа нэмж тайлагнана. Ингэхдээ 2015 оны 1-р улиралд тайлагнасан дүнг оруулахгүй ба зөвхөн тус улиралд нуун дарагдуулсан хөрөнгө, орлого, үйл ажиллагааг 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дүнд нэмж оруулна.

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Дархан Зочид Буудал ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

2015 оны 12 сарын 31 өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2014 оны 12-р сарын 31	2015 оны 12-р сарын 31-ний шинэчилсэн дүн ³
1	Борлуулалтын орлого (цэвэр)	401.856.839,42	320.799.833,63
2	Борлуулалтын өртөг	356.738.853,95	315.079.874,97
3	Нийт ашиг(алдагдал)	45.117.985,47	5.719.958,66
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	10.448,85	
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	61.422,00	
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	42.673.475,68	39.264.434,83
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	600.000,00	
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(8.632.832,69)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	1.916.380,64	(42.177.308,86)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1.916.380,64	(42.177.308,86)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1.916.380,64	(42.177.308,86)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	1.916.380,64	
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Захирал _____

Ерөнхий нягтлан бодогч _____



"DALAIYAN-AUDIT" CO.,LTD
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
© APPROVAL

³2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн тус дүнд 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө мэдүүлэх, бүртгүүлэх, тайлагнах үүргээ биелүүлээгүйн улмаас холбогдох албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа нэмж тайлагнана. Ингэхдээ 2015 оны 1-р улиралд тайлагнасан дүнг оруулахгүй ба зөвхөн тус улиралд нуун дарагдуулсан хөрөнгө, орлого, үйл ажиллагааг 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дүнд нэмж оруулна.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Дархан Зочид Буудал ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

2015 оны 12 сарын 31 өдөр
/төгрөгөөр/

№	УЗУУЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж толөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эзлийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийтдүн ⁴
1	2012 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл								
2	НББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайланг үеийн цэвэр ашиг (аллагдан)								
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	8,945,300.00		353,195,120.07	571,515,879.38			(135,546,168.52)	798,110,130.93
10	НББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
11	Залруулсан үлдэгдэл								
12	Тайланг үеийн цэвэр ашиг (аллагдан)							(42,177,308.86)	(42,177,308.86)
13	Бусад дэлгэрэнгүй орлого								
14	Өмчид гарсан өөрчлөлт								
15	Зарласан ногдол ашиг								
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
17	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	8,945,300.00		353,195,120.07	571,515,879.38			(177,723,477.38)	755,932,822.07

Захирал _____
Ерөнхий нягтлан болоч _____ (.....)



⁴2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн тус дүнд 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө мэдүүлэх, бүртгүүлэх, тайлагнах үүргээ биелүүлээгүйн улмаас холбогдох сабан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа нэмж тайлагнана. Ингэхдээ 2015 оны 1-р улиралд тайлагнасан бүнг оруулахгүй ба зөвхөн тус улиралд нунд ороогдсон хөрөнгө, орлого, үйл ажиллагааг 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дүнд нэмж оруулна.

10. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:

Компани нь 2015 онд 42.177.308.86 төгрөгийн алдагдалтай ажилласантай холбогдуулан ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосон ТУЗ-ийн шийдвэрийн дагуу ногдол ашиг хувиарлаагүй болно.

11. Компанийн тухай хуулийн 87,89 –р зүйлд заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл:

Компанийн тухай хуулийн 87,89 дүгээр зүйлд заасан их хэмжээний гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

12. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан:

2015 онд хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд хөдөлмөрийн сахилга батыг сайжруулах, зөв бүтцээр үр ашигтай ажиллах зохион байгуулалт хийж ажиллалаа.

Цалинг тодорхой хэмжээнд 1 удаа нэмэгдүүлсэн ба цалингын доод түвшин 350000 төгрөг, дундаж цалин 500.000 төгрөг байна.

Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх багаар ажиллаж үр дүн гаргах, эвсэг хамт олон бүрдүүлэх зорилгоор хамт олны дунд урлаг спортын, баяр ёслолын арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 2015 онд 3 ажилтанг тодорхойлж аймаг, сумын Засаг даргын жуух, ХХАА-н Тэргүүний ажилтан зэрэг орон нутгийн болон төрийн байгууллагын шагналаар шагнууллаа.

Ажилчдаа урамшуулж Улан-Үдэ хот руу нэг удаа аялуулав.

Цаашид өөрсдийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор боловсон хүчнийг сургах, мэргэшүүлэх, тэднийг хөгжүүлэх, ажилчдынхаа эрүүл мэндэд анхаарч ажиллаж байна.

Дотоод ажлын хүрээнд:

Тус (тайлангийн 3-р хэсэгт) үйлчилгээний соёл стандартыг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлуудыг өөрсдийнхөө эдийн засгийн боломж бололцоонд тулгуурлан зочид буудал, зоогийн газрынхаа дотоод болон гадаад орчны тохижилт, тоног төхөөрөмжийг засаж сэлбэн өнгө үзэмжийг сайжруулсан.

Манай компани нь тухай бүр СЗХ, МХБ-ийн сайтаар дамжуулан компанийн хувьцаа эзэмшигч, олон нийтэд компанийн тухай мэдээ, мэдээлэлийг журамд заасанаар хүргэн ажиллаж байна.

